



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 65

Мандалговь

Хөрөнгө дансанд бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.3-ын “б” заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сайнцагаан сумын 2-р цэцэрлэгийн 18 нэр төрлийн 44,330.400 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1 нэрийн 560,000 төгрөгийн тавилга, эд хогшил, **нийт 44,890.400** төгрөг, 3-р цэцэрлэгийн 3 нэр төрлийн 3,570.000 төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 1 нэрийн 11,700.000 төгрөгийн тавилга эд хогшил, **нийт 15,270.000** төгрөгийн, 4-р цэцэрлэгийн 2 нэр төрлийн 3,160.000 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3 нэр төрлийн 518,378.5 төгрөгийн тавилга, эд хогшил, **нийт 3,678,378.5** төгрөг, 5-р цэцэрлэгийн 8 нэр төрлийн 10,751.800 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1 нэрийн 2,520.000 төгрөгийн тавилга, эд хогшил, **нийт 13,271.800** төгрөг, 6-р цэцэрлэгийн 11 нэр төрлийн 9,583.500 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1 нэрийн 1,000,000 төгрөгийн барилга байгууламж, **нийт 10,583,500** төгрөг, 7-р цэцэрлэгийн 5 нэр төрлийн **5,500,000** төгрөгийн машин тоног төхөөрөмжийг, 8-р цэцэрлэгийн 7 нэр төрлийн **9,062.000** төгрөгийн машин тоног төхөөрөмжийг тус тус байгууллагын дансанд бүртгэх зөвшөөрөл олгосугай.

2. Орлогодох хөрөнгийн холбогдох бичиг баримтын бүрдлийг журмын дагуу хангаж дансанд бүртгэхийг тус байгууллагуудын нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллахыг Цэцэрлэгүүдийн эрхлэгч, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга нарт даалгасугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ